



Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

Цөмийн технологи-цацрагийн хамгаалалт,
аюулгүй байдал сарын аян

ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРТЭЙ
ХОЛБООТОЙ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮСЭГЧДЭД ЗОРИУЛСАН

ГАРЫН АВЛАГА

Засгийн газрын XII байр
Барилгачдын талбай-13
Улаанбаатар 15170
Харилцах утас: 265645

Цөмийн болон цацрагийн
аюулгүй байдлын хяналтын
газар

ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРТЭЙ ХОЛБООТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Цацрагтай холбоотой үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу дараах тусгай зөвшөөрлийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газраас авах ёстой. Үүнд:

1. Цацрагийн үүсгүүрийг эзэмших, ашиглах, худалдах;
2. Цацрагийн үүсгүүрийг угсрах, байрлуулах, түрээслэх, үйлдвэрлэх, ашиглалтаас гаргах, задлах, хадгалах;
3. Цацрагийн үүсгүүрийг тээвэрлэх, импортлох, экспортлох;
4. Цацрагийн үүсгүүрийн хаягдлыг булшлах, аюулгүй болгох болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

Эдгээр тусгай зөвшөөрлийг олгох болон хугацааг нь сунгах асуудлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2016 оны А/162 тоот тушаалаар батлагдсан “Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох дотоод журам”-ын дагуу, Цөмийн энергийн тухай хууль (ЦЭТХ)-ийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.5-д заасан нийт 14 төрлийн баримт бичгийн бүрдлийг хянан, цацрагийн аюулгүйн үнэлгээг хийсний үндсэн шийдвэрлэж байна. Тухайлбал, 1, 2, 4-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг 1-3 сарын дотор, 3-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг 3-14 хоногийн дотор шийдвэрлэдэг.

Цацрагийн үүсгүүр гэж юу вэ?

- ❖ Эмчилгээ оношилгоонд ашиглах богино наст цацраг идэвхт изотопууд, туяа эмчилгээний зайн шарлагын аппарат, дотуур шарлагын аппарат, компьютерт томограф, СPECT/CT, PET/CT, ангиограф, маммограф, суурин болон зөөврийн рентген аппарат;
- ❖ Аюулгүйн үзлэг, шалгалтад ашиглах рентген тоног төхөөрөмж;
- ❖ Аж үйлдвэрийн салбарт ашиглах суурин болон зөөврийн цөмийн хэмжүүр, ;
- ❖ Цооногийн каротажийн судалгаанд ашиглах цацраг идэвхт үүсгүүр;
- ❖ Геологи хайгуулын судалгаанд ашиглах рентген багаж, төхөөрөмж;
- ❖ Судалгаа шинжилгээний рентген тоног төхөөрөмж, тохируулгын үүсгүүр;
- ❖ Хүдэр болон баяжмалд эрдсийн агуулгыг тодорхойлох рентген флюоресценцийн анализын багаж төхөөрөмж зэрэг ионжуулагч цацраг гаргагч багаж хэрэгслийг цацрагийн үүсгүүрт тооцно.



Тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих ерөнхий шаардлага

Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан дээрх үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, тус улсад татвар төлөгч компани, хуулийн этгээдэд олгоно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

1. Үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх;
2. Үйл ажиллагаандаа хүний эрүүл мэндэд аюулгүй, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи ашиглах;
3. Үйл ажиллагаа нь ил тод, тогтвортой байх;
4. Болзошгүй ослын хохирлыг арилгах санхүү, эдийн засгийн чадавхтай байх.

Тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага

1. Техникийн болон аюулгүй ажиллагааны шаардлагыг бүрэн хангасан байх;
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан байх;
3. Компанийн засаглал болон нийгмийн хариуцлага, ёс зүйн талаарх дэлхий нийтэд хүлээн зөвшөөрсөн стандартыг хэвшүүлсэн байх;
4. Үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх.



Тусгай зөвшөөрлийг хэрхэн олгодог вэ?



Тусгай зөвшөөрлийг олгох

1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичиг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан тусгай зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг дээрх хугацаанд шийдвэрлэнэ.

2. Эдгээр тусгай зөвшөөрлийг олгоход Цөмийн энергийн комиссоос санал авсан байна.
3. Тусгай зөвшөөрөл хүсч ирүүлсэн баримт бичиг нь бүрэн бус шаардлага хангаагүй тохиолдолд зөвшөөрөл олгох боломжгүй ба тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэлийг зааж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.
4. Шаардлагатай тохиолдолд өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэнэ.

Тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах

Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсэгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.3-т зааснаас гадна дараах баримт бичгийг бүрдүүлж Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын газарт хүргүүлнэ.

Цацрагийн үүсгүүр импортлох тусгай зөвшөөрлийг авахад бүрдүүлэх баримт бичгүүд

№	Бүрдүүлэх баримт бичиг	Тайлбар
1.	Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (ААҮАТЗТ) хуулийн 11.1.1
2.	Өргөдлийн маягт	МХЕГ-ын вебсайтаас өргөдлийн маягтыг татаж, асуултын дагуу гүйцэт бөглөх
3.	Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1
4.	Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар.	Зөвхөн эмчилгээ оношилгоонд ашиглах цацрагийн үүсгүүрийг импортлох тохиолдолд.
5.	Нийлүүлж буй байгууллагатай хийсэн худалдах, худалдан авах гэрээний хуулбар;	
6.	Эцсийн хэрэглэгчийн талаарх мэдээлэл	Эцсийн хэрэглэгчийн үйл ажиллагааны танилцуулга, цацрагийн үүсгүүрийг ашиглах үндэслэл, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангасан эсэх, суурилуулах өрөө, боловсон хүчний талаарх танилцуулга;
7.	Цацрагийн үйлдвэрийн үзүүлэлтүүд, чанарын гэрчилгээ	Сериал дугаартай байх;

8.	Улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн баримт	itax.mta.mn вебсайт руу нэвтэрч төлбөрийн даалгавар үүсгэнэ. Татварын төрөл: улсын тэмдэгтийн хураамж Аймаг дүүрэг: Чингэлтэй, Сум/ хороо: Дүүргийн төвлөрсөн Хүлээн авагч байгууллага: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Холбоос сайт: https://itax.mta.mn/home/receiptCreate
----	---	---

Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүсэгч нь Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.5-д заасны дагуу дараах материалыг бүрдүүлнэ.

№	Бүрдүүлэх баримт бичиг	Тайлбар
1.	Тусгай зөвшөөрөл хүссэн албан бичиг	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (ААҮАТЗТ) хуулийн 11.1.1
2.	Өргөдлийн маягт	МХЕГ-ын вебсайтаас өргөдлийн маягтыг татаж, асуултын дагуу гүйцэт бөглөх
3.	Тусгай зөвшөөрөл хүсэгч аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;	Эмнэлэг бол эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хуулбарыг хамт ирүүлэх
4.	Эрхлэх үйл ажиллагааны зорилго, төрөл, үндсэн чиглэл, техник, эдийн засгийн үндэслэл	Тухайн байгууллагын үйл ажиллагааны танилцуулга, цацрагийн үүсгүүрийг ашиглах үндэслэл, цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажилладаг талаар дэлгэрэнгүй бичнэ. Цацрагийн хяналтын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын тэмдэглэлийн хуулбар, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан тухай тайланг хавсаргана.
5.	Мэргэжлийн боловсон хүчний танилцуулга	Цацрагийн үүсгүүр, рентген аппарат, тоног төхөөрөмжтэй ажиллах техникч, дотоод хяналтын ажилтан болон цацрагтай ажиллагч, техникчийн мэргэшлийн бэлтгэл, дипломын хуулбар, цацрагийн хамгаалалтын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;
6.	Цацрагийн аюулгүйн дотоод дүрэм	Харьяа аймаг, нийслэлийн цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчаар хянуулж батлуулсан байх;
7.	Цацрагийн аюулгүй байдлын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	
8.	Цацрагийн болзошгүй ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө	
9.	Дотоодын хяналт тавих алба, эсхүл хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр;	Байгууллагын дарга, захирлын тушаалаар цацрагийн хамгааллын ажилтныг томилсон байх, цацрагийн хамгаалалтын сургалтад 2 жил тутамд суусан байх.

10.	Ослын уршгийг арилгахад шаардлагатай нөөц боломж, хүч хэрэгслийн тухай танилцуулга	Цацрагаас хамгаалах хувийн хамгаалах хэрэгслийн талаарх мэдээлэл /нэр төрөл, зураг, тоо ширхэг/-ийг хүснэгтэд тусгаж ирүүлнэ. Үүнд, тухайн байгууллагад ашиглагдаж байгаа хамгаалах хэрэгслийн үнэн бодит мэдээллийг ирүүлнэ.
11.	Хяналтын багаж, түүний үзүүлэлт, баталгаажилтын гэрчилгээ;	Нэр төрөл, шинж чанар, идэвхийн хэмжээ, хэрэглэх зориулалт, аргачлал нь тодорхой бус цацрагийн үүсгүүрийг ашиглахыг хориглоно
12.	Цацрагийн үүсгүүрийн үйлдвэрийн гэрчилгээ, үзүүлэлтүүд, чанарын гэрчилгээ	Сериал дугаартай байх.
13.	Бусад байгууллагын байранд үйл ажиллагаа явуулдаг бол түрээсийн гэрээ	
14.	Импортын тусгай зөвшөөрлийн хуулбар	

Цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах тусгай зөвшөөрлийг **сунгуулахад** Цөмийн энергийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5-д заасны дагуу дараах материалыг бүрдүүлнэ.

№	Бүрдүүлэх баримт бичгүүд	Тайлбар
1.	Тусгай зөвшөөрлийг сунгуулах тухай албан бичиг	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай (ААҮАТЗТ) хуулийн 11.1.1
2.	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар /Зөвхөн эрүүл мэндийн салбар/
3.	Тусгай зөвшөөрлийн эх хувь	
4.	Улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн баримт	itax.mta.mn вэб сайт руу нэвтэрч төлбөрийн даалгавар үүсгэнэ. Татварын төрөл: улсын тэмдэгтийн хураамж Аймаг дүүрэг: Чингэлтэй, Сум/ хороо: Дүүргийн төвлөрсөн Хүлээн авагч байгууллага: Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Холбоос сайт: https://itax.mta.mn/home/receiptCreate
5.	Цацрагийн хяналтын ажилтны цацрагийн хамгаалалтын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар	Сүүлийн 2 жилийн хугацаанд цацрагийн хамгаалалтын сургалтад хамрагдсан байх.

Тусгай зөвшөөрлийн хугацаа

Цацрагийн үүсгүүрийг ашиглах тусгай зөвшөөрлийг тухайн үйл ажиллагааны онцлог, хяналт шалгалтын дүнг харгалзан 3 жил хүртэл хугацаагаар олгоно.

Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацааг дуусахаас 1-ээс доошгүй сарын өмнө уг зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдлөө хяналтын байгууллагад ирүүлэх,

Тусгай зөвшөөрлийг сунгах

1. Тухайн байгууллагын цацрагийн аюулгүй байдлын асуудлыг хариуцсан ажилтан шинээр томилогдсон, цацрагтай холбоотой үйл ажиллагааг 1-3 жил эрхлэж байгаа тохиолдолд нэг жилийн хугацаагаар сунгана;
2. Хяналт шалгалтаар “бага” болон “дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хангагдаж, цацрагийн аюулгүй байдлын соёл хэвшин, байгууллагын цацрагийн аюулгүйн алба, эсхүл цацрагийн аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтны мэргэшлийн бэлтгэл бүрэн хангагдсан тохиолдолд 2 жилийн хугацаагаар сунгана;
3. Цацрагийн аюулгүй байдлын соёлыг хэвшүүлсэн, цацрагийн аюулгүй байдлын шаардлага, боловсон хүчний мэргэшлийн бэлтгэл бүрэн хангагдсан тохиолдолд 3 жилийн хугацаагаар сунгана.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлийн шаардлагыг удаа дараа зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахгүй.

Улсын тэмдэгтийн хураамж

Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цацрагийн үүсгүүрийн ангиллыг харгалзан Монгол улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т заасны дагуу улсын тэмдэгтийн хураамжийг төлнө.

Хүсэлт гаргагч аж ахуйн нэгж, байгууллага нь улсын тэмдэгтийн хураамжийг тушаахдаа Татварын удирдлага, нэгдсэн системийн itax.mta.mn вебсайтаар нэвтэрч орон, төлбөрийн даалгавар үүсгэж, холбогдох хураамжийг тушаана.

itax.mta.mn/home/receiptCreate itax.mta.mn

ТӨЛБӨРИЙН ДААЛГАВАР ҮҮСГЭХ

Та Төрийн байгууллагаас авах үйлчилгээний төлбөр, хураамжийг төлөхдөө төлбөрийн даалгавар үүсгэж төлөх боломжтой боллоо. Жишээлбэл: Шинээр гадаад паспорт авах бол Улсын тэмдэгтийн хураамж төлөх байгууллага сонгоод өөрөө нэхэмжлэх үүсгэн төлөх боломжтой. Жишиг дүн харах бол энд дарна уу. /Төлбөрийн дүнг асуудал эрхэлсэн харьяа байгууллагаас лавлах шаардлагатайг анхаарна уу! /

Татвар төлөгчийн регистрийн дугаар *	2678047	Аймаг/ Дүүрэг *	35 - Чингэлтэй
Татвар төлөгчийн дугаар *	Си Ай Ти	Сум(хороо) *	3598 - Дүүргийн төвлөрсөн
Татварын төрөл *	01030701 - Улсын тэмдэгтийн	Хүлээн авагч байгууллага *	9128913: Мэргэжлийн хяналтын ер
Төлбөр хураамжийн төрөл *	4 - Бусад	Төлөх дүн	100,000.00 ₮
		Утас *	999999999

I'm not a robot

Татвар төлөгч: Суутгуулагч нь татвар төлөгчөөр бүртгэлтэй байна

Үүсгэх Буцах

Төлбөрийн даалгавар үүсгэх загвар

Тусгай зөвшөөрлийг дараах нөхцөлөөр хүчингүй болгоно.

1. Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан буюу хүчингүй болсон;
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
3. Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;
4. Олгосон тусгай зөвшөөрлийг засварласан;
5. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг ноцтой зөрчсөн;
6. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй.

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон шийдвэрийг уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногт багтаан зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэх ба түүнд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэлийг тодорхой заана. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулсан аж ахуйн нэгж, байгууллага нь тавьсан шаардлагыг биелүүлсэн нөхцөлд зөвшөөрөл авах хүсэлтээ дахин гаргаж болно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах шаардлага

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь үйл ажиллагаандаа Цөмийн энергийн тухай хууль, Цацрагийн аюулгүйн норм болон холбогдох бусад дүрмийн шаардлагыг чанд мөрдөж ажиллана.
2. Цацрагтай холбоотой үйл ажиллагааны онцлогт тохирсон цацрагийн аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, цацрагийн хамгаалалтын хөтөлбөр, ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж үйл ажиллагаандаа мөрдөнө.
3. Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагааг цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын шаардлагыг бүрэн хангасан, улсын байцаагчийн зөвшөөрсөн зориулалтын байранд явуулна.
4. Тухайн ажлын байр нь баталгаажсан, цацрагийн тун хэмжигч багажаар хангагдсан байна.
5. Цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан тухайгаа ажлын 3 хоногт багтаан мэдэгдэж, цацрагийн үүсгүүрийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.
6. Цацрагийн үүсгүүр бүхий аппарат тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийсэн болон цацрагийн үүсгүүрийг сольсон тохиолдолд цацрагийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэж хэмжилт, хяналт хийлгэнэ.
7. Цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл хөтөлж, жилийн эцсийн тооллого, ашиглалтын тайлан тооцоо, дотоод хяналтын дүнг жил бүрийн эцэст гарган ирүүлсэн байна.
8. Цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулж, цацрагийн тун хэмжигчээр хангана.
9. Цацрагтай ажиллагчийг мэргэжлээс шалтгаалах өвчин судлалын мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулна.
10. Цацрагтай ажиллагчийг төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн тусгай хөтөлбөрийн дагуу явагдах цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын сургалтад хамруулж, гэрчилгээ олгох;

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар